



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/312

Булган сум

Стандартын хэрэгжилтийн үзлэгийг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Стандарт, хэмжил зүйн газрын Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018 оны 16 дугаар тогтоол “Мал эмнэлгийн үйлчилгээний бүтэц, үйл ажиллагааны MNS 5368:2018 стандарт”-ын 10 дахь хэсгийн 10.1, 10.1.2 дахь заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/85 дугаар тоот тушаал, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагааны MNS 5368:2018 стандартын хэрэгжилтийн үзлэг зохион байгуулах удирдамжийг 1 дүгээр, стандартын хэрэгжилтийг үнэлж, дүгнэх зөвлөмжийг 2 дугаар, сумдад ажиллах ажлын хэсгийн шатахууны зардлыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Стандартын хэрэгжилтийн үзлэгийг удирдамжийн дагуу, тогтоосон хугацаанд зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн)-т даалгасугай.

3. Дээрх ажлыг зохион байгуулахад шаардагдах 934,099 (есөн зуун гучин дөрвөн мянга ерэн ес) төгрөгийг “Бэлчээрийн менежмент” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 26-ний өдрийн А/З 12 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

**МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГЖИЙН БҮТЭЦ,
ҮЙЛ АЖИЛЛАГАА MNS 5368:2018 СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТИЙН
ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ НЭГДСЭН УДИРДАМЖ**

Нэг. Үндэслэл, зорилго:

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.5.4, 31.6.10 дахь хэсэг, Стандарт, хэмжил зүйн газрын Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018 оны 16 дугаар тогтоолоор баталсан “Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагааны MNS 5368:2018 стандарт”-ын 10 дахь хэсгийн 10.1, 10.1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлох, үйл ажиллагааны хүрээг тогтоох, анхан шатны нэгжийн мөрдөж буй стандартын хэрэгжилтийг шалгаж үнэлгээ хийх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, үйл ажиллагааг сайжруулах, цаашид стандартын хэрэгжилтийг хангуулан үйлчилгээг тэгш хүртээмж, чанартай явуулах нөхцөлийг хангах зорилготой.

Хоёр. Стандартын хэрэгжилтийн үзлэгийг хамрах хүрээ:

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагааг MNS 5368:2018 стандартын хэрэгжилтийн үзлэгийг 16 сумын ерөнхий мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн 56 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг хамруулан зохион байгуулна.

Гурав. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

3.1. Мал эмнэлгийн газрын дарга нь харьяалах нутаг дэвсгэрт хийгдэх стандартын үзлэгийн бэлтгэл ажлыг хангуулах, удирдамж, асуумжийг МЭҮН-үүдэд урьдчилан хүргүүлэх, ажлын хэсэг байгуулан тогтоосон хугацаанд арга зүй, удирдамжийн хүрээнд үзлэг зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг шийдвэрлүүлэх, дүн мэдээг нэгтгэн хүргүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2. Сумын Мал эмнэлгийн тасаг нь батлагдсан удирдамж, зөвлөмж, арга зүйн дагуу харьяалах сумын хэмжээнд стандартын үзлэгийн бэлтгэл ажлыг хангуулах, стандартын үзлэг шалгалтыг тогтоосон хугацаанд зохион байгуулах, үр дүнг нэгтгэх, тайлагнах ажлыг хариуцна.

Дөрөв. Стандартын хэрэгжилтийн үзлэгийг хэрэгжүүлэх арга:

МЭЭГ-аас томилогдсон ажлын хэсэг орон нутгийн хяналтын улсын байцаагчтай хамтран үнэлнэ.

4.1 Стандартын хэрэгжилтийн үзлэгийг хэрэгжүүлэх ажлын хэсгийн гишүүд энэхүү удирдамжаар заасан асуудлын хүрээнд МЭҮН-ийн объектод үзлэг хийж, үйл ажиллагаатай газар дээр нь биечлэн танилцаж, холбогдох баримт бичиг, мэдээлэл, судалгааг гаргуулан авч, тэдгээрийг хянан үзэж, тайлбар авах, магадлах байдлаар батлагдсан асуумжийн дагуу үнэлгээ хийнэ.

4.2 Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааг шалгахдаа хяналтын хуудас болон шалгалтын тэмдэглэл үйлдэж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээг авч ажиллана.

4.3 Энэхүү удирдамжаар заасан хугацаанд стандартын хэрэгжилтийн үзлэгт хамрагдаагүй мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг үзлэгт тэнцээгүйтэй адилд тооцно.

4.4 Үнэлгээний хуудсанд үзлэг хийсэн ажлын хэсгийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

Тав. Стандартын хэрэгжилтийн ажлын хэсэг, маршрут: МЭЕГ-ын ажлын хэсэг, МЭГ-ын улсын байцаагч, МЭТ-ийн улсын байцаагч нар хамтран ажиллана.

Маршрут-1

Д/д	Сумын нэр	Ажиллах хугацаа	Ажлын хэсгийн ахлагч, гишүүд	Орон нутгаас ажлын хэсэгт ажиллах гишүүд
1	Рашаант	2024.05.03	Нийслэлийн Мал эмнэлгийн газрын хяналтын улсын байцаагч Б.Баттунгалаг, Мал эмнэлгийн газрын дарга Г.Одсүрэн	Сумын Засаг Даргын орлогч, Тамгийн дарга, Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч, тархвар зүйч,
2	Гурванбулаг	2024.05.04		
3	Могод	2024.05.06		
4	Хишиг-Өндөр	2024.05.08		
5	Бүрэгхангай	2024.05.10		
6	Баяннуур	2024.05.12		
7	Дашинчилэн	2024.05.14		
8	Орхон	2024.05.15		

Маршрут-2

Д/д	Сумын нэр	Ажиллах хугацаа	Ажлын хэсгийн ахлагч, гишүүд	Орон нутгаас ажлын хэсэгт ажиллах гишүүд
1	Сайхан	2024.05.03	Нийслэлийн Мал эмнэлгийн газрын Эрүүл мэндийн хэлтсийн дарга Ц.Гантөмөр, Мал эмнэлгийн газрын улсын байцаагч С.Уянга	Сумын Засаг Даргын орлогч, Тамгийн дарга, Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч, тархвар зүйч,
2	Баян-Агт	2024.05.04		
3	Хутаг-Өндөр	2024.05.05		
4	Тэшиг	2024.05.07		
5	Бугат	2024.05.09		
6	Сэлэнгэ	2024.05.10		
7	Хангал	2024.05.11		
8	Булган	2024.05.12		

Зургаа. Шалгалт эхлэх болон дуусах хугацаа: Стандартын хэрэгжилтийн үзлэгийг 2024 оны 05 дугаар сарын 03-наас 05 дугаар сарын 15-ны хугацаанд хэрэгжүүлнэ.

Долоо. Стандартын хэрэгжилтийн үзлэгийн дүнг тайлагнах: Мал эмнэлгийн газрын Улсын байцаагч сумдын тайланг нэгтгэн 2024 оны 05 дугаар сарын 20-ны дотор Мал эмнэлгийн газрын зөвлөлд танилцуулна.

- (*) – I зэрэглэлийн МЭҮН-д хамаарна.

D. Баримт бичгийн бүрдэл:

- Мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааны чиглэлээр хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээтэй
- Бүртгэлийн гэрчилгээнд мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэхээр бүртгэгдсэн байх
- Сум, дүүргийн Засаг дарга, Мал эмнэлгийн газар эсхүл тасагтай байгуулсан гурвалсан гэрээтэй
- Сум, дүүргийн Засаг дарга, Мал эмнэлгийн газартай байгуулсан гурвалсан гэрээ байгуулж, баталгааны тэмдэг авч цахим системд бүртгүүлсэн байх
- Мал эмнэлгийн ажил, үйлчилгээ үзүүлснийг баталгаажуулах баталгааны тэмдэгтэй, үйлчилгээг баталгаажуулдаг байх / дугаар, индекс, тайлбар /-Баталгааны тэмдэгтэй, үйлчилгээг баталгаажуулсан байх

E. Хүний нөөцийн чадавх:

- Малын эмч тухайн сумын байнгын оршин суугч болохыг нотолсон байх
- Тухайн сумын байнгын оршин суугч болохыг нотолсон E-Mongolia Иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа болон тухайн харьяа орон нутагтаа МЭ-ийн яаралтай дуудлага үйлчилгээ үзүүлэх, шуурхай бэлэн байдлын арга хэмжээ хэрэгжүүлэх чиг үүргээ хэрэгжүүлэн байнгын оршин суудаг талаар сумын Засаг даргын тодорхойлолт зэргийг үндэслэнэ.
- Мал эмнэлгийн техникийн ажилтанд малын их эмч удирдамж, мэргэжлийн заавар, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, санамж өгдөг байх
- Заавар өгч гарын үсэг зуруулан баталгаажуулсан байх

F. Барилга байгууламж:

- Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц үйл ажиллагаа MNS 5368:2018 стандартад заагдсан барилга, байгууламжийн ерөнхий болон тусгай шаардлагын боловсруулж, баталсан асуултын дагуу үнэлнэ.
- Барилга, байгууламжид тавигдах тусгай шаардлагын 27-28-р асуултад тухайн Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа барилгын нийт талбайг тооцон үнэлгээ өгнө.
- Барилга, байгууламжийн үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ, түрээсийн байртай тохиолдолд гэрээг үндэслэнэ.

G. Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангамж:

- Мал угаалгын суурин эсхүл зөөврийн ванн
- Баг, хорооны суурин ванн эсхүл мотопомп төхөөрөмжтэй байж болно.
- Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хүрэлцээ хангамж, бэлэн байдал, хэвийн ажиллагаатай эсэхийг харгалзан үзнэ.


H. Малын эм, бэлдмэлийн хэрэглээ нөөц:

- Эм, био бэлдмэлийн журам, зааврын дагуу хэрэглэдэг эсэх
- Тухайн нэгжид хэрэглэгдэж байгаа эм, био бэлдмэлийн хэрэглэх зааврын бүрдэл 80%-иас багагүй байх

I. Мал эмнэлгийн үйл ажиллагаа:

- Халдварт өвчний судалгаа, зураглал
- Сүүдийн 3-5 жилийн судалгаатай эсэх / бүртгэл, зураглалтай байх /
- Мал эмнэлгийн эмчилгээ, дуудлага, үйлчилгээ
- Сүүлийн 3 жилийн ажиллагааны бүртгэл, цахим мэдээллийн сан зэргийг үндэслэнэ.

----000----



СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЖ, ДҮГНЭХ ЗӨВЛӨМЖ

Ерөнхий мэдээлэл:

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5368:2018 стандартын хэрэгжилтийн үзлэгийг зохион байгуулах ажлыг хэсэг нь МЭҮН-ийн үйл ажиллагаатай газар дээр нь биечлэн танилцаж өгөгдсөн үзүүлэлтийг үзэж дүгнэнэ.

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн MNS 5368:2018 стандартын хэрэгжилтийн үзлэгийн асуумж нь мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагаа явуулах дараах эрх зүйн хүрээнд боловсруулагдсан, асуумжийн ихэнх нь Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5368:2018 стандартад заагдсан ерөнхий болон нийтлэг, тусгай шаардлагуудаас бүрдэж байгаа болно.

- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол
- ХХААХҮСайдын 2019 оны А-08 дугаар тушаал “Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийх, баталгааны тэмдэг хэрэглэх журам”
- ХХААХҮСайдын 2019 оны А-09 дугаар тушаал “ Мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, тайлагнах журам”
- ХХААХҮСайдын 2020 оны А-303 “Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журам”
- Стандарт, хэмжил зүйн газрын Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018 оны 16 дугаар тогтоолоор баталсан Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5368:2018 стандарт

Мал эмнэлгийн хяналтын улсын /ахлах/ байцаагч нь Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5368:2018 стандартын хэрэгжилтийг үнэлж, дүгнэхдээ дараах зөвлөмжийг мөрдлөг болгоно. Үүнд:

А. Стандартын хэрэгжилтийн үзлэг хийхдээ хяналт шалгалтын нийтлэг журамд нийцүүлэн хяналтын хуудасны үнэлгээний нэгэн адил буюу тухайн асуулт нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа тохиолдолд 0 оноогоор үнэлэх бөгөөд шаардлага хангахгүй тохиолдолд харгалзах түвшинд батлагдсан оноог өгөх, эсвэл тухайн шалгалтад хамрагдаж буй аж ахуйн нэгжид асуулт хамаарахгүй тохиолдолд “ хамааралгүй” гэсэн хариултаар үнэлнэ.

В. Тусгай шаардлагын асуултыг бөглөхдөө тухайн нэгжийн зэрэглэлд тохирч буй эсэхийг анхаарна. (*) (**) (***)

С. “Ерөнхий мэдээлэл” хэсэгт хүний нөөцийн чадавх, барилга байгууламжийн багтаамж, тоног төхөөрөмжийн хангамж, үйлчилгээний чадамжийг харгалзан мал эмнэлгийн нэгжийн зэрэглэлээ тогтоож, тухайн зэрэглэлд тохирсон / *- нэгжийн зэрэглэлийг ялгах тэмдэг / асуумжийн дагуу үнэлнэ.

- (*) (**) (***) - I, II, III зэрэглэлийн МЭҮН-д хамаарна.
- (*) (**) – I, II зэрэглэлийн МЭҮН-д хамаарна.

Аймгийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 06 ний өдрийн А/312 дугаар
захирамжийн 3 дугаар хэвсрэлт

СУМДАД АЖИЛЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН ШАТАХУУНЫ ТООЦОО

д/д	Сумын нэр	Сум хоорондын зай /км/	Шатахууны үнэ /төгрөг/	Нийт шатахуун /литр/	Дүн
1	2	3	4	5	6
Ажлын хэсэг – 1 (Рашаант, Гурванбулаг, Могод, Хишиг-Өндөр, Бүрэгхангай, Баяннуур, Дашинчилэн, Орхон,)20-40 БУН					
1	Булган-Рашаант	220	3680	39.6	145,728
2	Рашаант-Гурванбулаг	70	3680	12.6	46,368
3	Гурванбулаг-Могод	75	3680	13.5	49,680
4	Могод-Хишиг-Өндөр	70	3680	12.6	46,368
5	Хишиг-Өндөр- Бүрэгхангай	45	3680	8.1	29,808
6	Бүрэгхангай-Баяннуур	100	3680	18	66,240
7	Баяннуур-Дашинчилэн	30	3680	5.4	19,872
8	Дашинчилэн-Орхон	128	3680	23.04	84,787
9	Орхон-Булган	23	3680	4.14	15,235
	Нийт	761	3680	136.98	504,086
Ажлын хэсэг – 2 (Сайхан, Баян-Агт, Хутаг-Өндөр, Тэшиг, Бугат, Сэлэнгэ, Хангал, Булган) 00-16 БУЛ					
1	Булган-Сайхан	101	2520	18.18	45,814
2	Сайхан-Баян-Агт	72	2520	12.96	32,659
3	Баян-Агт-Хутаг-Өндөр	80	2520	14.4	36,288
4	Хутаг-Өндөр-Тэшиг	103	2520	18.54	46,721
5	Тэшиг-Бугат	298	2520	53.64	135,173
6	Бугат-Сэлэнгэ	101	2520	18.18	45,814
7	Сэлэнгэ-Хангал	80	2520	14.4	36,288
8	Хангал-Булган	113	2520	20.34	51,257
	Нийт	948	2520	170.64	430,013
	Бүгд дүн	1,709		308	934,099